

Цахим уулзалт боллоо

Бичсэн Administrator

2017 оны 9-р сарын 26, Мягмар гариг, 11:46



ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал доктор Шин Ён-Су 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс Монгол улсад албан ёсны айлчлал хийж байна. Айлчлалын хүрээнд өнөөдөр ЭМЯ-нд зочилж, яамны удирдлагын баг болон сонгогдсон аймгууд, ХОСҮТ, НЭМҮТ, ЗОСҮТ ОБЕГ-ын шуурхай удирдлагын нэгжүүдтэй ЭМЯ-ны Шуурхай удирдлагын товоос теле уулзалт хийлээ. Уулзалтын үеэр Монгол улсын эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдалтай танилцаж харилцан ярилцсан ба доктор Шин Ён-Су “Монгол улсад Олон улсын эрүүл мэндийн дүрмийн үндсэн чадавх бүрдсэнийг Хондлонгийн хамтарсан үнэлгээ харуулсан, цаашид хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахад Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх Үндэсний зохицуулагчийн үйл ажиллагааг оргожүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагаа, сүлжээг бүрдүүлэн бэхжүүлэх нь чухал” болох талаар дурдлаа.